



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар Б/11

Ховд

Б.Батсүхийг ажилд түр томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Авлигатай тэмцэх газраас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь хянагдаж ирэх хүртэл Базарын Батсүхийг аймгийн Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Батсүхийг Монгол улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дахь хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-10-4 дэх шатлал болох 1035204 төгрөг /нэг сая гучин таван мянга хоёр зуун дөрвөн/-өөр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 15 хувиар тооцож олгосугай.

3. Б.Батсүхийн ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

4. Албаны бүтэц, зохион байгуулалтыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, аймгийн Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/ нарт үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax B/11 Ch  
02 0486

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар  
сарын 04-ний өдрийн Б/11 дүгээр  
захирамжийн хавсралт



**АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн  
ахлагч: Ч.Багдал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Н.Эрдэнэцэцэг -Орон нутгийн өмчийн газрын ахлах  
мэргэжилтэн

Нарийн бичгийн  
дарга: Б.Болор-Эрдэнэ - Орон нутгийн өмчийн газрын нягтлан  
бодогч